

# ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АРГАЗҮЙН ТӨВ



Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгч, дэлхийн 120 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг, шашин, улс төрөөс ангид, олон улсын бие даасан төрийн бус байгууллага юм. “Хүүхэд хамгааллын аргазүйн төв”-нь Монгол улс дахь Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгаалал хөтөлбөрийн хүрээнд 2015 оноос үйл ажиллагаагаа явуулж байна.

## ЗОРИЛГО:

Хүүхэд хамгааллын ажилтнууд болон холбогдох бусад мэргэжилтнүүдийг чадавхижуулах аргазүйн олон талт үйл ажиллагаа явуулах замаар хүүхдийн эрхэд суурилсан хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах

## > ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ



### СУРГАЛТ

Хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох асуудлаар сэдэвчилсэн танхимын сургалтыг оролцогчдын хэрэгцээнд суурилан зохион байгуулдаг.



### Сургалтын хөтөлбөр, гарын авлага, удирдамж:

Хүүхэд хамгааллын чиглэлээр сургалтын хөтөлбөр, гарын авлага, удирдамж зэргийг боловсруулахад аргазүйн дэмжлэг үзүүлэн ажилладаг.



### Сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах танхим:

18-25 хүний багтаамж бүхий танхимыг сургалт, уулзалт, семинар, хэлэлцүүлгийн зориулалтаар ашиглаж болно.



### СУДАЛГАА

Хүүхэд хамгааллын тогтолцоонд учирч буй асуудал, бэрхшээлийг шинжлэх ухааны үндэстэй судлах болон энэ чиглэлийн судалгааны багт орж ажилладаг.



### МЭДЭЭЛЭЛ

Хүүхэд хамгааллын салбарын ажилтнууд болон бусад холбогдох хүмүүст зориулсан олон талт мэдээллийн бааз бүрдүүлж, цаасан болон цахим хэлбэрээр түгээдэг.



**Номын сан:** Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг нийгмийн ажилтнууд болон энэ чиглэлээр мэргэшиж буй оюутнуудад зориулан монгол хэлээр 190 төрлийн 600 гаруй, англи хэлээр 150 төрлийн 500 гаруй ном, гарын авлагыг танхимаар болон гэрээр олгож үйлчилж байна.



## ЗӨВЛӨГӨӨ

Хүүхэд хамгааллын ажилтнууд, бусад холбогдох мэргэжилтнүүд болон хүүхэд, эцэг эх, гэр бүлд зөвлөгөө өгөх



### Ажлын байран дахь

**зөвлөгөө:** Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар, ялангуяа хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд мэргэжлийн нийгмийн ажилтны гүйцэтгэх үүргийн талаар ажлын байранд очиж зөвлөгөө өгдөг.



**Нээлттэй семинар:** Хүүхэд хамгаалал болон нийгмийн ажлын онол, практиктэй холбоотой асуудлаар судлаач, мэргэжилтнүүдийг урьж семинар зохион байгуулдаг.



## НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүүхдийн эрх, хамгаалал, хүмүүжлийн эерэг аргуудыг сурталчлах үйл ажиллагааг боловсролын болон бусад институцитэй хамтран зохион байгуулдаг.


## > ЗОРИЛТОТ БҮЛЭГ

- Хүүхэд хамгааллын чиглэлээр бүх салбарт ажиллаж буй нийгмийн ажилтнууд
- Баг, хороо, сум, дүүргийн хүүхэд хамгааллын хамтарсан баг
- Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллах, мэргэших сонирхолтой нийгмийн ажилтан-оюутан
- Хүүхдийн хамгаалалтай холбогдох бусад талууд (багш, хэвлэл мэдээллийн ажилтан, олон нийт гэх мэт)
- Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө авах хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, гэр бүл

## АЖЛЫН ЦАГ

Ажлын өдрүүдэд 09:30-17:30 цаг  
Бямба гариг (шаардлагатай үед)

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо,  
28 дугаар байр 62 тоот  
☎ +976-70110885  
✉ [cpcc@savethechildren.mn](mailto:cpcc@savethechildren.mn)  
📍 Хүүхэд хамгааллын арга зүйн төв



## МАНАЙ ТӨВ ХУРАЛ, СУРГАЛТЫН ТАНХИМ ТҮРЭЭСЛҮҮЛНЭ



ВИДЕО ХУРАЛ  
ХИЙХ БОЛОМЖТОЙ



ӨНДӨР ХУРДАЙ  
ИНТЕРНЕТ



18-25 ХҮНИЙ  
БАГТААМЖТАЙ



СУРГАЛТЫН БҮХ  
ТОНОГЛОЛТОЙ